



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 20 өдөр

Дугаар 4/632

Булган сум

Дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, 8.1.5, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны XXV дугаар Хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 25/05 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Самбо бөхийн сурагч, өсвөр үе, залуучуудын дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд аймаг, орон нутгаа төлөөлөн оролцох Булган сумын ерөнхий боловсролын сургуулийн сурагч Чойжамцын Хажидсүрэнмаад дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэлхийн аваргын тэмцээнд оролцоход шаардлагатай 8.000.000 (найман сая) төгрөгийг Засаг даргын нөөцийн хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



6324010873